



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (603)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвтэл

2009 оны наймдугаар сарын 13 № 30 (603)

Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

431. Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай Дугаар 82 699

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

432. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 02 708

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

### Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 20.3, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 15.4, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 9.2, Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 5.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.5, Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.2, Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн 4.1.7, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Стандартчиллын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Эмийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, Аялал, жуулчлалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Эротикийн сурталчилгаанд хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 дугаар, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 6 дугаар, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг 7 дугаар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих үндэсний зөвлөлийн

бүрэлдэхүүнийг 8 дугаар, Төрийн хэлний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 10 дугаар, "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын Монголын хэсгийг бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Цэрэг, цагдаагийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 15 дугаар, Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн Монголын талын хэсгийн бүрэлдэхүүнийг 16 дугаар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 17 дугаар, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг 18 дугаар, Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсэг болон тэдгээрийн даргыг 20 дугаар хавсралт ёсоор баталсугай.



3. Энэ тогтоолын 20 дугаар хавсралтын 11, 12, 13, 25, 38, 39-д заасан салбар дундын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн ажлыг эрхлэх хүрээний Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлан ажиллуулж байсугай.

4. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүн болон Засгийн газрын агентлагийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр шинэчлэн баталж ажиллуулахыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын 3, 4 дүгээр зүйлд заасны дагуу сайдын тушаал болон Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар байгуулагдсан комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн салбарыг төлөөлөн орж байгаа албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

6. Байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын

хэсгийг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоол, "Гадаад сурталчилгааны тухай" Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 267 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай" Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл, "Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар тогтоол, "Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 198 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

## МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Сангийн сайд  
Орлогч дарга - Гадаад харилцааны дэд сайд  
Гишүүд: - Үндэсний аюулгүй байдлын  
Зөвлөлийн нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);  
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны  
Төрийн нарийн бичгийн дарга;  
- Гаалийн ерөнхий газрын дарга;  
- Татварын ерөнхий газрын дэд дарга;  
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэд  
дарга;  
- Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн  
газрын захирал;  
- Сангийн яамны Төсвийн бодлогын газрын  
дарга;  
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл,  
хяналт-шигжилгээ, үнэлгээний газрын дарга;  
- Батлан хамгаалах яамны Бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны  
Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын  
дарга;

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны  
Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газрын  
дарга;  
- Нийгмийн хамгаалах, хөдөлмөрийн яамны  
Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;  
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны  
Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;  
- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт-  
шигжилгээ, үнэлгээний газрын дарга;  
- Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө  
оруулалтын газрын дарга;  
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны  
Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн  
тэнхимийн дарга (тохиролцсоноор).  
Нарийн бичгийн дарга - Гадаад харилцааны  
яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын  
ажиллагааны газрын захирал

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

### СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Стандартчилал, хэмжил зүйн газрын  
дарга  
Гишүүд: - Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо,  
технологийн газрын дарга;  
- Шударга өрсөлдөөн, хэргэлэгчийн төлөө  
газрын дарга;  
- Оюуны өмчийн газрын дарга;  
- Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга;  
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэд  
дарга;

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд  
дарга;  
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны  
Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын  
дарга;  
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны  
Мэдээлэл, хяналт-шигжилгээ, үнэлгээний газрын дарга;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;

- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Тэргүүн шадар сайдын зөвлөх;

-Гадаад харилцааны яамны Хилийн боомтын бодлого хариуцсан тасгийн дарга;

- Зэвсэгт хүчний жанжин штабын Зэвсэгт хүчний хяналт, шалгалт, үнэлгээний газрын дарга;

- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;

- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэд дарга (тохиролцсоноор);

- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн үндэсний холбооны дарга (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Стандартчилал, хэмжил зүйн газрын ажилтан (орон тооны)

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

### ЭМИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Эрүүл мэндийн дэд сайд

Орлогч дарга - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд - Мал эмнэлэг, үржлийн газрын дэд дарга;

-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;

- Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;

-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан

мэргэжилтэн;

- Хүний эмийн салбар зөвлөлийн дарга;

- Малын эмийн салбар зөвлөлийн дарга;

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдал, үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга;

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга;

- Эрүүл мэндийн стандартчиллын техникийн хорооны дарга;

- Хөдөө аж ахуйн стандартчиллын техникийн хорооны дарга;

-Эм зүйн байгууллага, ажилтны нэгдсэн "Эм" холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга - Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

### АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Орлогч дарга - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд

Гишүүд - Соёл, урлагийн хорооны дарга;

-Нийслэлийн Засаг даргын орлогч /Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан/;

-Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал;

- Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга;

- Аялал, жуулчлалын холбооны тэргүүн (тохиролцсоноор);

- Аялал, жуулчлалын мэдээллийн төвийн гүйцэтгэх захирал;

- Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч(тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын газрын дарга

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

### ЭРОТИКИЙН СУРТАЛЧИЛГААНД ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга;

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга;

-Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;

-Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;

-Олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (тохиролцсоноор);

- Төрийн соёрхолт зохиолч Б.Догмид;

- "Монгол кино" нэгтгэлийн ерөнхий захирал Ж.Солонго;

- Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;

- ДОХ-ын үндэсний төвийн захирал;

- Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэлийн тэргүүлэгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

### ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд  
 Орлогч дарга - Цөмийн энергийн газрын дарга  
 Гишүүд - Сангийн сайд;  
 - Гадаад харилцааны сайд;  
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний сайд;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;  
 - Батлан хамгаалахын дэд сайд;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын

яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Тагнуулын ерөнхий газрын дарга;  
 - Онцгой байдлын ерөнхий газрын дарга;  
 - Гаалийн ерөнхий газрын дарга;  
 - Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч.  
 Нарийн бичгийн дарга - Цөмийн энергийн газрын дэд дарга

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

### УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

газрын дарга  
 сайд;  
 салбарын сайд;  
 Улаанбаатар хотын захирагч;  
 аймаг, сумын Засаг дарга;  
 дэд дарга;  
 дарга;

Дарга - Монгол Улсын Шадар сайд  
 Орлогч дарга - Онцгой байдлын ерөнхий  
 Гишүүд - Батлан хамгаалахын сайд;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
 - Эрүүл мэндийн сайд;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний сайд;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд;  
 - Эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон  
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
 - Нутаг дэвсгэр дээр нь онцгой байдал үүссэн  
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн  
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн

Нарийн бичгийн дарга;  
 Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Тагнуулын ерөнхий газрын дарга;  
 - Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга;  
 - Гаалийн ерөнхий газрын дарга;  
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга;  
 - Хил хамгаалах ерөнхий газрын дарга;  
 - Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга;  
 - Цөмийн энергийн газрын дарга;  
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;  
 - Стандартчлал, хэмжил зүйн газрын дарга;  
 - Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга;  
 - Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/;  
 - Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга.

Нарийн бичгийн дарга /орон тооны/

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС, ТЭДГЭЭРИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

сайд  
 Зөвлөлийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;  
 - Гаалийн ерөнхий газрын дарга;  
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;  
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга;  
 - Тагнуулын ерөнхий газрын дарга;

- Хил хамгаалах ерөнхий газрын дарга;  
 - Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын захирал;  
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга;  
 - Малын эмийн салбар зөвлөлийн дарга;  
 - Сэтгэцийн эмгэг, наркологийн төвийн захирал.  
 Нарийн бичгийн дарга - Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга

## Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

### ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

нарийн бичгийн дарга;  
 бодлогын газрын дарга;  
 дарга;  
 томъёоны асуудал хариуцсан газрын дарга;

Дарга - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд  
 Гишүүд - Гадаад харилцааны яамны Төрийн  
 - Оюуны өмчийн газрын дарга;  
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн  
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
 - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хуулийн нэр томъёоны асуудал хариуцсан газрын дарга;

- Шинжлэх ухааны академийн нийгмийн ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч;  
 - Монгол Улсын Их Сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн захирал;  
 - Монгол Улсын Боловсролын их сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал;  
 - Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга.  
 Нарийн бичгийн дарга - Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал.

**Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт**
**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Хууль зүй, дотоод хэргийн сайд  
 Гишүүд - Сэлэнгэ аймгийн Засаг дарга;  
 - Сангийн дэд сайд;  
 - Эрүүл мэндийн дэд сайд;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;  
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Нийслэлийн Засаг даргын орлогч /Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан/;  
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга;  
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга;

- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);  
 - Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор);  
 - "Улаанбаатар ротари клуб"-ийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
 - Хүнс үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);  
 - Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор).  
 Нарийн бичгийн дарга - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга

**Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт**
**"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд  
 Орлогч дарга - Сангийн сайд  
 Гишүүд - Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;  
 - Гадаад харилцааны дэд сайд;  
 - Батлан хамгаалахын дэд сайд;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд;  
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга;  
 - Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга  
 Нарийн бичгийн дарга - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга

**Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт**
**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд  
 Орлогч дарга - Сангийн сайд;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний сайд.  
 Гишүүд - Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);  
 - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);  
 - Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);  
 - Монгол Улсын Шадар сайд;  
 - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;  
 - Гадаад харилцааны сайд;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;  
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;  
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;  
 - Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөх;  
 - Эрүүл мэндийн дэд сайд;  
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга;  
 - Хүүхдийн төлөө газрын дарга;  
 - Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч;  
 - Үндэсний статистикийн хорооны Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын дарга;  
 - Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;  
 - Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал;  
 - Монгол Улсын Их Сургуулийн Цөмийн судалгааны төвийн захирал;  
 - Тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөлийн дарга;  
 - Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
 - Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын сүлжээний тэргүүн (тохиролцсоноор);  
 - Монголын Байгаль орчны төрийн бус байгууллагуудын холбооны тэргүүн (тохиролцсоноор);  
 - Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).  
 Нарийн бичгийн дарга - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын дарга

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 13 дугаар хавсралт

## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд  
Орлогч дарга - Эрүүл мэндийн сайд  
Гишүүд: - Байгаль орчин, аялал жуулчлалын  
сайд;  
- Батлан хамгаалахын сайд;  
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;  
- Үндэсний статистикийн хорооны дарга  
(зөвшилцсөнөөр);  
- Ерөнхийлөгчийн Нийгмийн бодлогын зөвлөх  
(зөвшилцсөнөөр);  
- Ерөнхий сайдын Нийгмийн бодлогын зөвлөх;  
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;  
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;  
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд  
сайд;  
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;  
- Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд;  
- Эрүүл мэндийн дэд сайд, Дархлаажуулалтын  
сангийн зөвлөлийн дарга;  
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн  
бичгийн дарга;

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны  
Төрийн нарийн бичгийн дарга;  
- Нийслэлийн Засаг даргын орлогч /нийгмийн  
хөгжлийн асуудал хариуцсан/;  
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;  
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;  
- Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга;  
- Гадаад харилцааны яамны Олон улсын  
байгууллагын газрын захирал;  
- Зэвсэгт хүчний жанжин штабын Ар талын  
газрын дарга;  
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн  
захирал;  
- Монголын улаан загалмай нийгэмлэгийн дэд  
ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах  
нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);  
- Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний  
холбооны тэргүүн (тохиролцсоноор).  
Нарийн бичгийн дарга - Эрүүл мэндийн яамны  
Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 14 дүгээр хавсралт

## АРХИВЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд  
Гишүүд: - Архивын ерөнхий газрын дарга;  
- Гадаад харилцааны яамны Төрийн  
захиргааны удирдлагын газрын дарга;  
- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн  
захиргааны удирдлагын газрын захирал;  
- Шинжлэх ухааны академийн Түүхийн  
хүрээлэнгийн захирал;

- Үндэсний төв архивын захирал;  
- Зэвсэгт хүчний төв архивын дарга;  
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архивын  
асуудал хариуцсан ажилтан;  
- Архивын ерөнхий газрын Судалгаа, арга зүй,  
хяналтын хэлтсийн дарга.  
Нарийн бичгийн дарга - Архивын ерөнхий  
газрын Бодлого зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 15 дугаар хавсралт

## ЦЭРЭГ, ЦАГДААГИЙН БАГИЙГ НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД БЭЛТГЭХ, ОРОЛЦУУЛАХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн  
бичгийн дарга  
Орлогч дарга - Гадаад харилцааны яамны Олон  
улсын байгууллагын газрын захирал  
Гишүүд: - Сангийн яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын дарга;  
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн  
захиргааны удирдлагын газрын дарга;  
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын дарга;

- Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;  
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга;  
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга;  
- Зэвсэгт хүчний Жанжин штабын Энхийг  
сахиулах газрын дарга;  
- Тагнуулын ерөнхий газрын Сөрөх тагнуулын  
газрын дарга.  
Нарийн бичгийн дарга - Батлан хамгаалах  
яамны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах  
мэргэжилтэн.

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 16 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, АМЕРИКИЙН НЭГДСЭН  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХАМТАРСАН ЗӨВЛӨЛИЙН МОНГОЛЫН  
ТАЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Гадаад харилцааны сайд  
 Гишүүд: - Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд;  
 - Гадаад харилцааны яамны Америк, Ойрхи дорнод, Африкийн газрын захирал;  
 - Сангийн яамны Зээл, тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газрын дарга;  
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт-шиожилгээ, үнэлгээний газрын дарга;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал, жуулчлалын газрын дарга;  
 - Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;  
 - Гаалийн ерөнхий газрын хяналт шалгалт хариуцсан дэд дарга;

- Үндэсний статистикийн хорооны Аргачлал, судалгааны газрын дарга;  
 - Монгол банкны Валютын газрын захирал;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;  
 - Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
 - Онцгой байдлын ерөнхий газрын Тамгын газрын дарга;  
 - Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, арга зүйн хэлтсийн дарга;  
 - Стандартчилал, хэмжил зүйн төвийн Стандартчилал, тохирлын үнэлгээний газрын стандартчиллын менежер.  
 Нарийн бичгийн дарга - Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын Америкийн Нэгдсэн Улс хариуцсан мэргэжилтэн

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 17 дугаар хавсралт

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Монгол Улсын Шадар сайд  
 Орлогч дарга-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч  
 Гишүүд: - Төв аймгийн Засаг дарга, Шагайн харвааны салбар хорооны дарга;  
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн нийгмийн бодлогын зөвлөх /зөвшилцсөнөөр/;  
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд;  
 - Гадаад харилцааны дэд сайд, Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны дарга;  
 - Батлан хамгаалахын дэд сайд, Хурдан моринь салбар хорооны дарга;  
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, үндэсний бөхийн салбар хорооны дарга;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Урлаг, соёлын салбар хорооны дарга;

- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, үндэсний сурын салбар хорооны дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Улаанбаатар хотын ерөнхий менежер, Төхижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооны дарга;  
 -Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга;  
 - Биений тамир, спортын газрын дарга;  
 - Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга, Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар хорооны дарга;  
 - Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга;  
 - Биений тамир, спортын газрын Спортын анагаах ухааны албаны дарга;  
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.  
 Нарийн бичгийн дарга-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

Засгийн газрын 2009 оны 82 дугаар  
тогтоолын 18 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд  
 Орлогч дарга - Хууль зүй, дотоод хэргийн сайд  
 Гишүүд: - Хүний эрхийн үндэсний комиссын дарга (зөвшилцсөнөөр);

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);  
 - Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч;



- Улсын Ерөнхий прокурорын орлогч;  
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;  
 - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;  
 - Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;  
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Зөм, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга;  
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;  
 - Хүүхдийн төлөө газрын дарга;  
 - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал;  
 - Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэд ерөнхийлөгч /тохиролцсоноор/;  
 - Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;

- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;  
 - Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн тэргүүн /тохиролцсоноор/;  
 - Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 - Хүний эрх ба хөгжил төвийн тэргүүн /тохиролцсоноор/;  
 - "Глоб интернейшнл" байгууллагын тэргүүн /тохиролцсоноор/;  
 - "Эрх чөлөө төв" төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 - Монголын оюуны өмч эзэмшигчдийн эрхийг хамгаалах холбооны тэргүүн /тохиролцсоноор/;  
 - Нээлттэй нийгэм Форумын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 - Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн /тохиролцсоноор/;  
 - Монголын хүний эрхийн төвийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 - Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 - "Эмнэсти Интернейшнл"-ийн Монголын үндэсний хорооны гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;  
 Нарийн бичгийн дарга - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

**Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 19 дүгээр хавсралт**

**ГАДААД СУРТАЛЧИЛГАА, СОЁЛЫН ХАРИЛЦААГ  
ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга - Гадаад харилцааны сайд  
 Гишүүд - Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;  
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;  
 - Нийслэлийн Засаг даргын орлогч /Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/;  
 - Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга;  
 - Байгалийн тамир, спортын газрын дарга;  
 - Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;  
 - Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн дарга (тохиролцсоноор);  
 - МОНЦАМЭ агентлагийн захирал;  
 - Монгол үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);  
 - Олон улсын монгол судлалын холбооны ерөнхийлөгч(тохиролцсоноор);

- Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал (тохиролцсоноор);  
 - Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
 - Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);  
 - Монголын урчуудын эвлэлийн холбооны дарга (тохиролцсоноор);  
 - Монголын зохиолчдын эвлэлийн хорооны дарга (тохиролцсоноор);  
 - Энх тайван, найрамдлын төлөө Монголын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
 - Урлагийн бирийн захирал (тохиролцсоноор).  
 Нарийн бичгийн дарга - Гадаад харилцааны яамны хэвлэл, мэдээллийн хэлтсийн дарга

**Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 20 дугаар хавсралт**

**ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ҮНДЭСНИЙ ХОРОО,  
АЖЛЫН ХЭСЭГ, ТЭДГЭЭРИЙН ДАРГА**

№	Комисс, үндэсний хороо, ажлын хэсэг	Дарга
1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллагын асуудал эрхэлсэн Монголын комисс	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
2	Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
3	Монголын түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, хэдгалан хамгаалах асуудлыг эрхлэх улсын комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
4	Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
5	Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
6	Үйлдвэрийн осол, байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын Монголын хэсэг	Монгол Улсын Шадар сайд
7	Улсын ургацын комисс	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
8	Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

9	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын үндэсний хороо	Гадаад харилцааны сайд
10	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/-ын Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
11	"Бүх нийтийн экологийн боловсрол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
12	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
13	Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
14	Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
15	Эрхлэх ажлын хүрээний Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
16	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах улсын комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
17	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
18	Уур амьсгалын үндэсний хороо	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
19	Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хороо	Хууль зүй, дотоод хэргийн сайд
20	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих үндэсний зөвлөл	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
21	Хулгайн гэмт хэргтэй тэмцэх хөтөлбөрийн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
22	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
23	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах бэлтгэлийг хангах ажлын хэсэг	Батлан хамгаалахын сайд
24	Засгийн газрын худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Сангийн сайд
25	Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
26	Монголын мэдээлэл, холбооны технологийн үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
27	Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо	Сангийн сайд, МҮХАҮТ-ын дарга
28	Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагаа, худалдааны олон талт хэлэлцээнд Монгол Улсын баримтлах байр суурь, удирдамжийг боловсруулах, Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын ажлын хэсэг	Гадаад харилцааны сайд
29	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
30	Эрхлэх ажлын хүрээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
31	Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үндэсний хороо	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
32	"Сонгодог урлаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
33	Хүн ам, хөгжлийн асуудлаархи үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
34	Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
35	Зүүн хойд азийн орнуудын хамтын ажиллагааг бүс нутгийн хөгжлийн шинэ нөхцөл, шаардлагад нийцүүлэн идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх Засгийн газрын ажлын хэсэг	Сангийн сайд

36	Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах үндэсний хороо	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
37	Ховор ургамлын үндэсний зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
38	Олимпид бэлтгэх үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
39	"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл	Монгол Улсын Шадар сайд
40	Жендерийн тэгш байдлын үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
41	Гадаад худалдааны нэг цэгийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэг	Сангийн сайд
42	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
43	Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг удирдан зохицуулах үндэсний хороо	Гадаад харилцааны сайд
44	Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг удирдан зохион байгуулах зөвлөл	Сангийн сайд
45	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаархи салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах зөвлөл	Монгол Улсын Ерөнхий сайд
46	Агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний хороо	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
47	Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсад 2007-2011 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэсний хэмжээнд мониторинг хийх Удирдах хороо	Гадаад харилцааны сайд
48	"Хүнсний баталгаат байдал" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
49	Үйлдвэржилттэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл	Монгол Улсын Тэргүүн шадар сайд

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.00 цаг

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд П.Очирбат, Н.Жанцан, Ж.Болдбаатар, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа /илтгэгч/, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгаалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Баяраа, Улсын Их Хурлын даргын 2009 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 74 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Зоригт нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой

албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэв.

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Баяраа Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хандаж гаргасан мэдээллэдээ:**

"...Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Онцгой албан татварын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж "эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам долларын, импортын литр пиво тутамд 0.50 ам долларын онцгой албан татвар ногдуулах"-аар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим хэсгийг эрсэсэн тухай нэр бүхий иргэний гомдлоор Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянан шийдвэрлэгдэж, Үндсэн хуулийн цэцийн дунд

суудлын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар 2/03 дугаар дүгнэлт гарсан.

Уг дүгнэлтээр "эх орны үйлдвэрийн болон импортын пивоны татварын хувь хэмжээг ялгамжтай ногдуулахаар хуульчилсан" аар Монгол Улс 1997 онд кодгэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын "Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр"-ийн удиртгал хэсгийн "Тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх" гэсэн заалт, 1 дүгээр зүйлийн "Үндэсний нэн тааламжтай нөхцөл", 3 дугаар зүйлийн "Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл"-ийг зөрчсөн, ингэснээр Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж дүгнэсэн байна. Улмаар Монгол Улсын Их Хурал 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолоороо Үндсэн хууль зөрчсөн болохоо хүлээн зөвшөөрч Үндсэн хуулийн цэцийн 2/03 тоот дүгнэлтийг авсанаар цэцийн дүгнэлт эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

Гэтэл Улсын Их Хурал 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталж, Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 5 дахь заалтын "Импортоор авсан бараа"-нд хамаарах "0.20" гэснийг "0.35" гэж татварын хувь хэмжээг нэмэгдүүлэн хуульчилж эх орны болон импортын пивоны татварын хувь хэмжээг харилцан адилгүй, ялгамжтай тогтоосноороо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтээр хүчингүй болгосон Онцгой албан татварын тухай хуулийн хүчингүй болсон заалтыг татварын хувь хэмжээг нь өөрчлөх замаар агуулгаар нь шууд сэргээсэн байна.

Монгол Улсын Их Хурал дээрх Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн дахин зөрчсөн төдийгүй Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг үл ойшоосон хариуцлагагүй үйлдэл гаргасан байна.

Мөн түүнчлэн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасан "хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим" болох тухай заалт, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Жаран долдугаар зүйлийг агуулгаар нь зөрчсөн байх бөгөөд төрний эрх барих дээд байгууллага нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа, илтэд санаатай зөрчсөн шийдвэр гаргаж эх орны үйлдвэрийн болон импортын бараа бүтээгдэхүүнд татварын ялгамжтай, тэгш бус нөхцөл тогтоосноороо Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улс орнуудын өмнө тэр дундаа Монгол Улсад пиво импортолж гишүүн орнуудын өмнө хариуцлагагүй, хууль тогтоомжийн хувьд тогтворгүй гэсэн орсон үр дагавар бүхий үнэлэлтийг авчрахаар үйлдэл гаргасан байна.

Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцэрийн 2 дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 2-т "Хэлэлцэн тохиролцож аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохиролцож аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолсон бараанд

дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хувь хэмжээнээс илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй" гэснийг Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр баталсан "Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн "... мөн хүснэгтийн 5 дахь заалтын "Импортоор авсан бараа"-нд хамаарах "0.20" гэснийг "0.35" гэж гэсэн хэсэг шууд зөрчсөн байх бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлт болон түүнийг хүлээн зөвшөөрсөн Улсын Их Хурлын 2005 оны 36 дугаар тогтоолоор эцэслэн шийдвэрлэгдсэн маргаантай энэхүү мэдээлэл нь хууль зүйн үр дагавар хийгээд агуулгын хувьд адилхан (зөвхөн татварын хувь хэмжээ л өөрчлөгдсөн) болно.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр баталсан "Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн "... мөн хүснэгтийн 5 дахь заалтын "Импортоор авсан бараа"-нд хамаарах "0.20" гэснийг "0.35" гэж гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу ногдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн талаар дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

**Хоёр. Үндсэн хуулийн цэцийн үх суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацэцэг, Д.Зоригт нар Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 5 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн тайлбартаа:**

"... 1. Улсын Их Хурал 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэ хуулийн 1 дүгээр зүйлээр импортын пивонд харгалзах онцгой албан татвар "0.20" байсныг "0.35" гэж өөрчилсөн юм.

Хуулийн дээрх заалт Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцэрийн 3 дугаар зүйлийн 2-ын "Хэлэлцэн тохиролцож аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохиролцож аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолсон бараанд дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хураамжаас илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын бусад хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна гэж үзэж иргэн Б.Баяраа өргөдөл гаргажээ.

Энэхүү Ерөнхий хэлэлцэрт дотоодын үйлдвэрлэлийн тодорхой салбарт шаардлагатай тарифын хамгаалалтыг хэрэглэж болохуйцаар тарифын бүтцээ аль болох уян хатан байлгах боломжийг хөгжиж буй орнуудад олгосон байдаг. Тухайлбал, Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцэрийн 18 дугаар зүйлийн 2-т "Хэлэлцэн тохиролцож талууд өөрсдийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор импортод нөлөөлөх хамгаалалтын буюу бусад арга хэмжээг авах шаардлагатай байж болох бөгөөд тухайн арга хэмжээ нь энэхүү хэлэлцэрийн зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох учраас тэдгээрийг зүй ёсны гэж хэлэлцэн



тохиролцогч талууд мөн хүлээн зөвшөөрч байна” гэж заасан байна. Энэ нь хөгжлийн түвшин доогуур, эсхүл, хөгжиж эхэлж байгаа улс дэлхийн худалдааны байгууллагын дүрмийг ягштал биелүүлэх шаардлагагүй гэсэн санааг агуулж байна гэж үзэж байна.

Иймд Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар импортын пивонд онцгой албан татварын хэмжээг ялгавартай тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь заалтын: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй бөгөөд энэ нь үндэсний пиво үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилготой, Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалтын арга хэмжээ гэж үзэж байна.

Нөгөө талаар Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр нь "... олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоо байгуулах..." үндсэн зорилготой байдаг, түүнчлэн мөн хэлэлцээрээр барааг "аль нэг өөр орноос гарал үүсэлтэй, эсхүл, түүн рүү илгээж буй аливаа бараанд олгосон давуу тал, хөнгөлөлт, дархан эрх ямба нь Хэлэлцэн тохирогч бусад бүх Талын нутаг дэвсгэрээс гаралтай эсхүл эдгээр нутаг дэвсгэр рүү илгээж буй ижил бараанд ямар нэг болзолгүйгээр тэр даруй олгогдоно" гэдгийг хэлэлцэн тохирогч талууд зөвшөөрсөн байдаг. Энэ нь тодорхой төрлийн барааны хувьд аливаа улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж буй татварын хэмжээ хэлэлцэн тохирогч бусад улсынхтай ойролцоо букуу хэт зөрүүгүй байх гэсэн санааг агуулж байна гэж үзэж байна. Гэтэл манайд пиво импортлогч орнуудын пивонд ногдуулж буй татварын хувь хэмжээ манай улсад мөрдөгдөж буй татварын хувьд хэмжээнээс зарим талаар хэт өндөр байна.

Нэмж хэлэхэд, дэлхийг хамарсан санхүүгийн хямралын нөхцөлд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд уг асуудлыг ялгавартайгаар тогтоосон бөгөөд импортлоор оруулах пивоны онцгой албан татварыг нэмэгдүүлэхдээ дотоод зах зээлээс гадагш тэмүүлж байгаа валютын урсгалыг аль болох хумих бодлогын хүрээнд уг асуудлыг авч үзсэн болно.

Нөгөө талаар импортын пиво тээвэрлэлтийн явцад халах, хөрөх зэргээр чанар нь муудаж борлуулах явцад хадгалах хугацаа нь дууссах гэх мэтээр хэрэглэгчийн эрх ашгийг хожиорох явдал гардаг. Иймд дотооддоо хямд үнэтэй, чанартай, шэнэ пиво үйлдвэрлэн зах зээлийн хэрэгцээг хангах явдлыг татварын бодлогоор зохицуулах нь хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн арга хэмжээ юм.

Er нь Онцгой албан татварын хууль маань бүхэлдээ импортлогч, дотоодын үйлдвэрлэгч нарт ялгавартай татварын тариф тогтоох зохицуулалттай бөгөөд пивоноос гадна хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнд ийнхүү татварын ялгамжтай тариф хэрэглэснийг энд дурдах нь зүйтэй байна” гэжээ.

### ҮНДЭСЛЭЛ:

Эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд ялгавартай татвар ногдуулсан нь Үндсэн хууль

зөрчсөн болохыг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлт гарснаас хойш 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлах хүртэл хугацаанд Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээрүүд болон Монгол Улсаас тус байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудад өөрчлөлт ороогүй байхад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн болох нь Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2/03 дэх хэсгийн хүснэгтийн ... 5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж ... өөрчилсүгэй” гэж эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд онцгой албан татварыг ялгавартайгаар ногдуулахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн байх тул 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “... 5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж өөрчилсөн хэсгийг хүчингүй болгосугай.

2. Улсын Их Хурлаас 2006 оны 6 дугаар сарын 29-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 5 дахь заалт хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН  
П.ЧИРБАТ  
Ж.БОЛДБААТАР  
Ц.НАРАНЧИМЭГ  
Д.САРАНТУЯА  
Д.МӨНХГЭРЭЛ  
Б.ПҮРЭВНЯМ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхэтгэлийн редакци.

Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12

Төрийн ордон-128 тоот

и-мэйл: turin\_medeel@parliament.mn



262420, 329612

Индекс 14003



329487

Хэвлэлийн хуудас 1.5